

Д вирус хепатит

В вирус хепатиттай өвчтөнүүдэд зориулав

Д вирус хепатит гэж юу вэ?


Д вирус хепатит нь хепатитийн Д вирус (ХДВ)-ээр үүсгэгддэг халдварт өвчин бөгөөд вирус хепатитийн бусад хэлбэрүүдээс хамгийн хүндээр элгийг гэмтээдэг юм. Зөвхөн В вирус хепатиттай өвчтөнүүдэд ХДВ халдварлах боломжтой бөгөөд В вирус хепатиттай 20 өвчтөн тутмын 1 нь ХДВ-ийн хавсарсан халдвартай байна.

Яагаад би шинжилгээнд хамрагдах ёстой вэ?

Зөвхөн ХВВ-ийн халдвартай өвчтөнүүдтэй харьцуулахад ХДВ-ийн халдвар хавсрах нь элэгний хатуурал болон элэгний хавдар үүсэх явцыг хурдасгана. Хепатитийн В, Д вирусийн хавсарсан халдвартай өвчтөнүүдийг хянах, эмчлэх заавар нь дан ХВВ-ийн халдвартай өвчтөнүүдийнхээс ялгаатай байдаг.

Дараах тохиолдолд ХДВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаарай:

- Та Африк, Зүүн Европ, Ойрхи Дорнод, Монгол, Пакистан болон Төв Азиас гаралтай бол
- Та В вирус хепатитийн эмийн эмчилгээнд хамрагдсан ч эмчилгээ үр дүнгүй эсвэл элэгний үйл ажиллагааны үзүүлэлтүүд ихэссэн хэвээр байвал
- Та элэгний хатууралтай гэж оношлогдсон бол



Би шинжилгээнд хэрхэн хамрагдах вэ?

Танд ХДВ-ийн эсрэг бие (anti- HDV) илрүүлэх шинжилгээ хийнэ. Энэ нь цусанд хийгддэг энгийн шинжилгээ бөгөөд ХВВ-ийн халдвартай өвчтөнүүдэд ХДВ-ийн хавсарсан халдварыг оношлох эхний алхам юм. Хэрвээ уг шинжилгээний хариу эерэг гарвал ХДВ-ийн нуклейн хүчлийг тодорхойлох шинжилгээ хийж оношийг баталгаажуулна. Мөн гэр бүлийн гишүүд болон бэлгийн хамтрагчаа шинжилгээнд хамруулах хэрэгтэй.

Хэрвээ би ХВВ/ХДВ-ийн хавсарсан халдвартай бол яах ёстой вэ?

Та архи, тамхи, согтууруулах ундаа, элгэнд нөлөөлөх эмийн болон химийн бодисын зохисгүй хэрэглээнээс зайлсхийх, хепатитийн А вирусийн эсрэг дархлаажуулалтанд хамрагдан элэг болон бие махбодио эрүүл байлгах нь чухал. Эмчлэгч эмч тань ХДВ-ийн үржлийг дарангуйлах, элэгний гэмтлээс сэргийлэх зорилгоор танд пег-интерферон болон бусад эмчилгээг зөвлөнө.